

САРЕХ.MN ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ

/Шинэчилсэн огноо: 2022.03.01/

Энэхүү үйлчилгээний нөхцөл нь нэг талаас “Капекс Капитал” ХХК /цаашид ВХҮҮ гэх/ нөгөө талаас хэрэглэгч /цаашид “Хэрэглэгч” гэх/ хооронд виртуал хөрөнгийн биржийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой үүсэх харилцааг зохицуулна.

Та энэхүү гэрээтэй сайтар уншиж танилцан “Хүлээн зөвшөөрч байна” гэсэн баталгаажуулалтыг хийсний дараагаар САРЕХ.MN виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн холбогдох үйлчилгээг авах эрх үүсэх ба түүнд хамаарах үйлчилгээний дараах эрсдэлүүдийг мэдэж, хүлээн зөвшөөрөх шаардлагатай.

НЭГ. Нэр томъёоны тодорхойлолт

- 1.1. “Сарех.mn виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч” гэж Арилжаанд оролцогчийн виртуал хөрөнгө худалдах, худалдан авах захиалгын биелэлтийг хангах зориулалт бүхий цахим системийг;
- 1.2. “Арилжаа” гэж ВХҮҮ дээр виртуал хөрөнгийг мөнгөн хөрөнгөөр арилжих, мөнгөн хөрөнгийг виртуал хөрөнгөөр арилжиж, виртуал хөрөнгийг Виртуал хөрөнгөөр арилжих гүйлгээг;
- 1.3. “Виртуал хөрөнгө” гэж Аливаа улсын албан ёсны мөнгөн тэмдэгт, үнэт цаасны дижитал хэлбэр, эсхүл Монголбанкны зөвшөөрөлтэй цахим мөнгөнөөс бусад дижиталаар шилжүүлэх, арилжаалах үнэ цэнийн дижитал илэрхийлэл бүхий эдийн бус хөрөнгийг;
- 1.4. “Фиат” гэж Аливаа улсын албан ёсны мөнгөн тэмдэгтийг;
- 1.5. “Шилжүүлэг” гэж Биржийн харилцагч нарын хэтэвч хооронд, Бирж болон гуравдагч виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч эсхүл хэтэвчний үйлчилгээ үзүүлэгчийн хэтэвч хооронд гүйцэтгэгдэж буй виртуал хөрөнгийн гүйлгээг;
- 1.6. “Цахим хэтэвч” гэж ВХҮҮ дээр хэрэглэгчийн үүсгэн удирдах, хэрэглэгчийн үүсгэн удирдах, хэрэглэгчийн Мөнгөн хөрөнгө, Виртуал хөрөнгийн үлдэгдэл болон гүйлгээний мэдээллийг агуулсан дахин давташгүй ID дугаар бүхий цахим дансыг;
- 1.7. “Үйлчилгээний нөхцөл” гэж Сарех.mn ВХҮҮ-ээс харилцагч нарт одоо болон ирээдүйд санал болгож буй тухайлсан виртуал хөрөнгийн үйлчилгээний мэдээлэл, шалгуур, харилцагч үйлчилгээг ашиглахад мөрдөх журам зэрэг үндсэн болон бусад нөхцөлийг тусгасан нийтэд нээлттэй байршуулсан цахим баримт бичгийг;
- 1.8. “Харилцагч” гэж Гэрээ болон Бүртгэлийн шалгуур, Харилцагчид тавигдах шаардлагыг хангаж, танин баталгаажуулалт хийсэн, тухайлсан виртуал хөрөнгийн Үйлчилгээний нөхцөлийг тусгасан нийтэд нээлттэй байршуулсан цахим баримт бичгийг;
- 1.9. “Хэрэглэгчийн бүртгэл” гэж ВХҮҮ-ийн системд үйлчилгээний нөхцөлийг хүлээн зөвшөөрч үүсгэсэн дахин давташгүй бүртгэлийг (account);
- 1.10. “Үйлчилгээний шимтгэл” гэж Үйлчилгээний нөхцөл болон Сарех.mn ВХҮҮ-ээс баталсан Үйлчилгээний шимтгэлийн нөхцөлд тусгасан шимтгэлийг;
- 1.11. “МУТС” гэж Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхийг;
- 1.12. “Өндөр эрсдэлтэй харилцагч” гэж Улс төрд нөлөө бүхий этгээд, МУТС-тай тэмцэх чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас МУТС-тай тэмцэх хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж зарлагдсан улсын хүн, хуулийн этгээд, МУТС-тай тэмцэх үндэсний эрсдэлийн үнэлгээгээр өндөр эрсдэлтэй гэж үнэлэгдсэн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа хүн, хуулийн этгээдийг;

- 1.13. “Улс төрд нөлөө бүхий этгээд” гэж Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20.2-т заасан этгээд бүхий байгууллагаас баталсан бусад журам, заавар заасан албан тушаалтныг ойлгоно;
- 1.14. “Виртуал хөрөнгө гаргагч” гэж ИЕО хийх замаар ВХҮҮ-ийн харилцагч нарт виртуал хөрөнгийг худалдаж, хөрөнгө татан төвлөрүүлж буй компанийг;
- 1.15. “Initial Exchange Offer” /ИЕО/ гэж Биржээс хамтын ажиллагааны гэрээ байгуулсны үндсэн дээр Виртуал хөрөнгө гаргагчийн виртуал хөрөнгийг Биржийн харилцагч нарт санал болгон худалдан замаар хөрөнгө татан төвлөрүүлэх ажиллагааг;

ХОЁР. Хариуцлагын мэдэгдэл

- 2.1. Виртуал хөрөнгө нь хууль ёсны мөнгөн тэмдэгтэд хамаарахгүй бөгөөд Засгийн газар, Төв банк, Санхүүгийн зохицуулах хорооноос баталгаажуулагдахгүй болно.
- 2.2. Виртуал хөрөнгө нь хадгаламжийн даатгал, зээл, бонд, үнэт цаас биш бөгөөд үнэний хөрөнгө оруулагчдыг хамгаалах аливаа даатгалд хамаардаггүй болно.
- 2.3. Үйлчилгээ үзүүлэгч нь зөвхөн виртуал хөрөнгийн биржийн үйлчилгээ үзүүлэх бөгөөд Виртуал хөрөнгөтэй холбоотой арилжаа, татвар, хууль эрх зүйн талаарх зөвлөгөө өгөх үүрэггүй.
- 2.4. Хэрэглэгч нь Санхүүгийн зохицуулах хороо болон МонголБанк бусад шаардлагатай зөвлөмж мэдэгдлүүдийг өөрөө уншиж танилцан судлах үүргийг хүлээнэ.
- 2.5. Хэрэглэгчийн арилжаанд оролцсоноос шалтгаалан үүссэн үр дүнд үйлчилгээ үзүүлэгч хариуцлага хүлээхгүй.
- 2.6. Хэрэглэгч өөрийн бүртгэлийг хаалгүй (logout) орхисноос шалтгаалсан эсхүл нэвтэрч буй төхөөрөмжид сануулж орхисноос үүдсэн нэвтрэх нэр алдагдах түүнтэй холбоотой эрсдэлд үйлчилгээ үзүүлэгч хариуцлага хүлээхгүй.
- 2.7. Хэрэглэгч өөрийн хувийн мэдээллийг бусдад задруулахгүй байхыг үүргийг хүлээнэ.
- 2.8. Үйлчилгээ үзүүлэгч нь арилжаатай холбоотой бүхий л асуудлаар баталгаа гаргахгүй байх үүргийг хүлээнэ.
- 2.9. Үйлчилгээ үзүүлэгч нь энэхүү үйлчилгээний нөхцөлийг хэдийд ч нэмэлт өөрчлөлт бүрэн эрхтэй бөгөөд шинэчлэгдсэн үйлчилгээний нөхцөлийг [Sarex,mn /tearms/](http://Sarex.mn/tearms/) хуудсанд байршуулж сүүлд шинэчилсэн гэх огноог өөрчилнө.
- 2.10. Хэрэглэгч шинэчлэгдсэн үйлчилгээний нөхцөлийг системд байршуулсан эсвэл хэрэглэгчдэд мэдээлснээс хойш Sarex.mn ВХҮҮ-г үргэлжлүүлэн ашиглавал тэдгээрийг хүлээн зөвшөөрсөнд тооцогдоно.
- 2.11. Виртуал хөрөнгийн талаарх олон улсын хэм хэмжээ, дотоодын хууль тогтоомжоос хамаарч виртуал хөрөнгийн үйлчилгээ болон үнэ цэнэ огцом өөрчлөгдөх /буурах, өсөх/-д үйлчилгээ үзүүлэгч хариуцлага хүлээхгүй.
- 2.12. Зах зээлд оролцогчдын эрэлт хэрэгцээнээс хамаарч үнэ цэнийн хэлбэлзлийн үр дагавраар алдагдал хүлээхэд үйлчилгээ үзүүлэгч хариуцлага хүлээхгүй.
- 2.13. Sarex.mn ВХҮҮ-ийн үйлчилгээнд технологийн хүндрэл гарсан тохиолдолд харилцагч өөрийн виртуал хөрөнгийг ашиглах, хэрэглэх боломжгүй болно.
- 2.14. ВХҮҮ-ийн өмчилж, эсхүл эзэмшиж байгаа хөрөнгө нь харилцагчид учирсан хохирлыг бүрэн барагдуулж хүрэлцэхгүй байх эрсдэлтэй.
- 2.15. Sarex.mn ВХҮҮ-ийн үйлчилгээгээр дамжиж буй мэдээллийг хадгалах боловч тэдгээрийн үнэн зөв байдал, хэрэглээ, холбоотой байдал, хэрэгцээт байдалд баталгаа өгөхгүй бөгөөд тэдгээр контентын агуулгаас шууд болон шууд бусаар учирсан аливаа хохирлыг хариуцахгүй.

- 2.16. Сарех.mn үйлчилгээний талаарх мэдээлэл нь Харилцагчийг хараат бусаар шийдвэр гаргахад нь туслалцаа үзүүлэхэд чиглэх бөгөөд аливаа мэдэгдэл өгөлгүйгээр өөрчлөгдөх боломжтой.
- 2.17. Үйлчилгээний нөхцөлд хэрэгжүүлэхээр заасан аливаа заалт хэрэгжээгүй, хойшлогдсон нь байгалийн гамшигт үзэгдэл, цахилгаан, эрчим хүчний уналт, тасалдал, төрийн байгууллагын шийдвэр, иргэдийн бослого хөдөлгөөн, террорист халдлага, гал түймэр, цар тахал зэрэг эдгээрээр хязгаарлагдахгүй ВХҮҮ-ийн боломжит хяналтаас гадуурх аливаа үйлдэл, эс үйлдэхүй, хүчин зүйлсийн үр дагаварт хамаарах бол ВХҮҮ аливаа хариуцлага хүлээхгүй.
- 2.18. Үйлчилгээний нөхцөлийн аль нэг хэсэг нь хүчин төгөлдөр бус болохыг эрх бүхий байгууллагаас тогтоосон нь Үйлчилгээний нөхцөлийг бүхэлд нь болон бусад хэсгийг хүчингүй болгох үндэслэл болохгүй бөгөөд тэдгээр нь үйлчилсэн хэвээр байна.

ГУРАВ. Хэрэглэгчийн бүртгэл үүсгэх

- 3.1. Хэрэглэгч нь Сарех.mn ВХҮҮ-ийн системд нэвтэрч үйлчилгээ ашиглахын тулд дор дурдсан мэдээллийг үнэн зөв бөглөн өөрийн бүртгэл болон цахим хэтэвчийг үүсгэсэн байх шаардлагатай.
 - a. Өөрийн овог нэр;
 - b. Регистрийн дугаар;
 - c. Утасны дугаар;
 - d. Цахим шуудангийн хаяг;
 - e. Бусад.
- 3.2. Дээрх мэдээллүүд хэрэв анх бүртгүүлснээс хойш өөрчлөгдсөн тохиолдолд шинэчлэн хадгалах эсхүл үйлчилгээ үзүүлэгчид мэдэгдэх;
- 3.3. Хэрэв таны өмнөөс хэн нэгэн өөр этгээд бүртгүүлсэн сэжигтэй тохиолдол илэрвэл үйлчилгээ үзүүлэгчид мэдэгдэх, шалгуулах;
- 3.4. Бүртгэл үүсгэх явцад виртуал хөрөнгийн биржийн үйл ажиллагаатай холбоотой аюулгүй байдлын зөрчлийг илрүүлсэн эсхүл төсөөтэй сэжигтэй тохиолдол байна гэж үзвэл үйлчилгээ үзүүлэгчид мэдэгдэх;
- 3.5. Хэрэглэгч бүртгэл үүсгэхдээ өөрийн идэвхтэй ашигладаг цахим шууангаа бүртгүүлэх шаардлагатай бөгөөд үйлчилгээтэй холбоотой аливаа мэдээ мэдээлэл, мэдэгдлийг тухайн бүртгэлтэй цахим шуудангаар хүргүүлэх бөгөөд цахим шуудангийн хувийн тохиргооноос шалтгаалсан цахим шуудан хүлээн авах боломжгүй тохиолдолд үйлчилгээ үзүүлэгч нь түүнээс үл хамааран тантай харилцах мэдээ, мэдээлэл, мэдэгдлийг хүргүүлсэнд тооцно.
- 3.6. Хэрэглэгч өөрийн хэрэглэгчийн бүртгэл, цахим хэтэвчний аюулгүй байдлыг хангах үүргийг хүлээнэ.

ДӨРӨВ. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч дээрх арилжаа

- 4.1. Арилжаа нь дараах төрлүүдтэй байна. Үүнд:
 - 4.1.1. Харилцагч өөрийн ВХҮҮ-ийн хэтэвч дэх мөнгөн хөрөнгөөр виртуал хөрөнгө худалдан авах
 - 4.1.2. Виртуал хөрөнгийг өөр виртуал хөрөнгөөр солих
 - 4.1.3. Виртуал хөрөнгийг худалдаж мөнгөн хөрөнгө болгох
- 4.2. ВХҮҮ-ээс харилцагчид арилжааны захиалга хийх дараах аргуудыг санал болгоно. Үүнд:
 - 4.2.1. Тухайлсан хэмжээ, ханш тогтоож өгөх захиалга (limit orders)

- 4.2.2. Захиалга бүртгэл дэх хамгийн боломжит ханшаар биелэх, хэмжээ тогтоосон захиалга (market orders)
- 4.2.3. Тухайлсан хэмжээ, ханш тогтоож өгөх замаар алдагдлыг хязгаарлах захиалга (stop limit orders)
- 4.3. Харилцагч гадаадын эсхүл дотоодын ангилал дах виртуал хөрөнгөөс сонгож, ВХҮҮ-ийн “Арилжаа” хэсгээс ханшийн мэдээллийг харж захиалга өгөх боломжтой.
- 4.4. Харилцагч ВХҮҮ дээрх зөвхөн өөрийн Хэтэвчийг ашиглан арилжааны захиалга хийх боломжтой бөгөөд харилцагчийн сонгосон захиалгын араас хамаарч ВХҮҮ-ийн систем захиалгын тухай бүр гүйцэтгэнэ.
- 4.5. Авах, зарах захиалга нь зөвхөн харилцагчийн үйлдэлд үндэслэх бөгөөд захиалга биелсэн тухай бүр харилцагчийн хэтэвч дэх мөнгөн хөрөнгө эсхүл виртуал хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт орно.
- 4.6. Тухайлсан арилжааны түүх нь захиалгын төрөл, захиалга өгсөн виртуал хөрөнгө бүхий хослол, түүний ханш, хэмжээ, захиалга биелсэн эсхүл цуцлагдсан хугацаа зэрэг бусад мэдээллийг агуулна.
- 4.7. Тухайлсан хэмжээ, ханш тогтоосон авах, зарах захиалгын хувьд зарах, авах захиалга хэсэгчлэн эсхүл бүхэлдээ тохирохгүй тохиолдолд хугацаа тогтоогоогүй бол харилцагч тус захиалгыг цуцлах хүртэл эсхүл бусад хэд хэдэн харилцагчийн захиалгатай тохирох хүртэл хугацаанд захиалгын бүртгэлд нээлттэй байршина.
- 4.8. Харилцагчийн платформд хийх нийт зарлагын шилжүүлгийн дээд хэмжээ ВХҮҮ тогтооно.
- 4.9. ВХҮҮ-ээс тухайлсан виртуал хөрөнгийн болон үйлчилгээг таниулах, арилжааны хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор харилцагч нарын дунд зарласан урамшуулалт арга хэмжээ, хөтөлбөр, идэвхжүүлэлтийн ажлын хүрээнд хийгдэх арилжааны захиалгад баримтлах дүрмийг тусгайлан тогтоож олно.
- 4.10. ВХҮҮ-ийн техникийн сайжруулалт, шинэчлэлт, засвар үйлчилгээ, тухайлсан виртуал хөрөнгийн олон улсын зах зээл дэх ханшийн хэт өсөлт болон хэт уналт, виртуал хөрөнгийн болон сүлжээний форк, кибер халдлага, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны явцад харилцагчийн арилжааны захиалга авахгүй байх, захиалга цуцлагдах эрсдэлийг ВХҮҮ-ийн цахим хуудсаар дамжуулан мэдэгдэнэ.
- 4.11. ВХҮҮ дээр арилжаалах виртуал хөрөнгийн жагсаалт нь олон улсын болон дотоодын зах зээлд арилжаалагдаж буй виртуал хөрөнгө болон ВХҮҮ-ээр дамжуулан нийтэд санал болгох ажиллагаа амжилттай болж бүртгэгдсэн виртуал хөрөнгүүдээс бүрдэнэ.
- 4.15. Виртуал хөрөнгө гаргагч нь ВХҮҮ-ийн Арилжааны жагсаалт дахь өөрийн гаргасан виртуал хөрөнгийн үнэ ханшийг огцом унахаас сэргийлэх зорилгоор ВХҮҮ-тэй тохиролцож, холбогдох гэрээ байгуулсан тохиолдолд түүний үндсэн дээр өөрөө эргүүлэн худалдан авах ажиллагааг хийх тохиолдолд энэ талаар харилцагч нарт ВХҮҮ-ийн цахим хуудсаар дамжуулан урьдчилж мэдээлнэ.

ТАВ. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч дээрх орлого, зарлага болон шилжүүлэг

- 5.1. Хэрэглэгч нь өөрийн бүртгэл болон цахим хэтэвчээр дамжуулан дижитал хөрөнгийн бирж дээрх бүх төрлийн зөвшөөрөгдсөн виртуал хөрөнгө арилжиж, хадгалж, бусдад шилжүүлэх эрхтэй.
- 5.2. Хэрэглэгч нь мөнгөн дүнгээр цахим хэтэвчийг цэнэглэхдээ зөвхөн төргөгөөр хийх бөгөөд хэрэв бусад валютаар хийх тохиолдолд хэрэглэгчийн шилжүүлэг хийж буй банкны валютын ханшаар хөрвөж тооцогдоно.

- 5.3. Орлого, зарлага хийхэд тухайн хэрэглэгчийн харилцдаг банк болон блокчэйн сүлжээний шимтгэл, хурднаас шалтгаалан шилжүүлгийн хэвийн дундаж хугацаанаас удах, мөн алдаатай мэдээлэл оруулсан, шилжүүлгийн шимтгэл дутсанаас шалтгаалан шилжүүлгийн хэвийн дундаж хугацаанаас удах, мөн алдаатай мэдээлэл оруулсан, шилжүүлгийн шимтгэл дутсанаас шалтгаалан буцаж болно.
- 5.4. Виртуал хөрөнгийн шилжүүлэг хийх хаягаа буруу оруулсан, шилжүүлэг хийгдсэн тохиолдолд үйлчилгээ үзүүлэгч хариуцахгүй.
- 5.5. Хэрэглэгч өөрийн орлого, зарлага, арилжааны түүхийг устгуулах хүсэлт гаргасан ч бусад хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах үүднээс уг түүхийг дижитал хөрөнгийн биржийн системээс устгахгүй. Хэрэглэгч арилжааны ханш, тоо хэмжээг буруу оруулж, захиалга биелсэн тохиолдолд арилжааг буцаах боломжгүй.
- 5.8. Ханшийн зөрүүнээс хариулт үүссэн тохиолдолд хэрэглэгчид хариултыг шилжүүлнэ.
- 5.9. Шилжүүлэг нь буцаах боломжгүй, залилан мэхлэх шинжтэй, эсхүл алдаатай гүйлгээнээс үүдэн гарах үр дагавар, нөхөн төлөгдөхгүй.
- 5.10. Шилжүүлэг нь хийгдсэн хугацаанаас үл хамааран бүртгэлийг системд бүртгэгдсэн хугацаагаар гүйлгээ хийгдсэнд тооцогддог.

ЗУРГАА. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр дамжуулж Виртуал хөрөнгийг олон нийтэд санал болгох буюу Initial Exchange Offering /IEO/

- 6.1. Харилцагч ВХҮҮ-ийн платформд нэвтрэн, Launchpad хэсэгт дарж, ВХҮҮ дээр зарлагдсан IEO-д оролцох боломжтой.
- 6.2. Харилцагч IEO-д оролцохоос өмнө ВХҮҮ-д байршуулсан тухайн виртуал хөрөнгийн анхдагч арилжааны захиалга авах хугацаа, ВХҮҮ дээр анхдагч арилжааг нээх хугацаа, виртуал хөрөнгийн нэрлэсэн нэгж үнэ, анхдагч арилжаагаар нийт захиалга авах тоо ба татан төвлөрүүлэх мөнгөний хэмжээ, ВХҮҮ дээр захиалга авах тоо ба татан төвлөрүүлэх мөнгөний хэмжээ, нэг харилцагч IEO-д оролцох дээд болон доод хязгаарлалтын мэдээлэл, виртуал хөрөнгийн танилцуулгын холбоосоор мэдээлэлтэй танилцаж үйлчилгээг авна.
- 6.3. Харилцагч IEO-д оролцохдоо захиалгын тоо, хэмжээг нягтлах, анхаарал болгоомжтой байх бөгөөд захиалгыг буцаахгүй тул буруу захиалга өгсөнтэй холбоотой үр дагаврыг харилцагч зөвхөн өөрөө хариуцах ба ВХҮҮ аливаа хариуцлага хүлээхгүй.
- 6.4. ВХҮҮ дээрх IEO-д оролцох эсэх нь зөвхөн харилцагчийн өөрийн сонголт байх тул Та үйлчилгээг авах эсэхийг сонголтыг сайтар эргэцүүлсний үндсэн дээр шийдвэрлэхийг сануулж байна.
- 6.5. ВХҮҮ виртуал хөрөнгийн IEO-г хийсэн нь тухайн виртуал хөрөнгөд аливаа байдлаар баталгаа өгч буй хэлбэр биш бөгөөд Арилжааны явцад тухайн виртуал хөрөнгийн ханшийн өөрчлөлтөд ВХҮҮ аливаа хариуцлага хүлээхгүй.

ДОЛОО. Хэрэглэгчийн хориглох буюу хязгаарлах үйлдэл

- 7.1. Хэрэглэгч ВХҮҮ-ийн үйл ажиллагааг мөнгө угаах, залилан мэхлэх, мэдээлэл барьцаалах, терроризмыг санхүүжүүлэх зэрэг хууль бусаар ашиглахыг хориглоно;
- 7.2. Хэрэглэгч нь өөрийн бүртгэлийг үүсгэхдээ өөрийн хувийн мэдээллийг санаатайгаар буруу оруулсан, оруулахыг завдсан, олон нийтэд илтгэд худал мэдээллийг тараасан, ВХҮҮ-ийн үйл ажиллагаанд аюул учруулахуйц үйлдэл хийсэн, арилжааны ханшийг өсгөж бууруулсан

манупилац хийсэн үйлдэл нь тогтоогдсон тохиолдолд хэрэглэгчийн бүртгэлийг түр хаах, дахин ашиглах боломжгүйгээр устгах, зарим үйлдлийг бүрэн хязгаарлана.

- 7.3. Эрх бүхий байгууллагаас хэрэглэгчийн арилжаанд хөрөнгө оруулж буй мөнгөн хөрөнгийн эх үүсвэрийн талаарх, эсхүл хэрэглэгчийн шаардлагатай мэдээллийг шаардлагатай тохиолдолд үйлчилгээ үзүүлэгч гаргаж өгөх үүргийг хүлээнэ.

НАЙМ. Хууль тогтоомжийн хариуцлага

- 8.1. Хэрэглэгч нь Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжид дагаж мөрдөх үүрэгтэй.
- 8.2. Хэрэглэгч арилжаанд оролцсоноос шалтгаалсан татварын хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид заасан төлбөр хураамжийг бие даан шийдвэрлэх үүрэг хүлээнэ.
- 8.3. Эрх бүхий байгууллагаас хэрэглэгчийн арилжаанд хөрөнгө оруулж буй мөнгөн хөрөнгийн эх үүсвэрийн талаарх, эсхүл хэрэглэгчийн шаардлагатай мэдээллийг шаардлага тохиолдолд үйлчилгээ үзүүлэгч шаардлагатай мэдээллийг гаргаж өгөх үүргийг хүлээнэ.
- 8.4. ВХҮҮ нь олон улсын хууль хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагуудтай нээлттэй хамтран ажиллах тул хуулийн дагуу шалгаж тогтоосон тохиолдолд Харилцагчийн хэтэвчийг царцаах, хаах, арга хэмжээг шууд авна.

ЕС. Үйлчилгээний нөхцөл дуусгавар болох

- 9.1. Хэрэглэгч үйлчилгээний нөхцөл дуусгавар болгох хүсэлтийг гаргасан тохиолдолд үйлчилгээ үзүүлэгч хэрэглэгчийн бүх эрхийг эсхүл хэсэгчилж хаах боломжтой.
- 9.2. Хэрэглэгч дуусгавар болох хүсэлтээ info@capexcapital.mn цахим хаягаар илгээнэ.
- 9.3. Бүх эрхийг хаалгах хүсэлт илгээх үед тухайн хэрэглэгчийн биелээгүй захиалгыг цуцлах боломжтой бөгөөд биелсэн захиалгыг цуцлах боломжгүй.

АРАВ. Нууцлалын бодлого

- 10.1. Үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгчийн мэдээллийг нууцлалын бодлогын дагуу эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн 3 дах этгээдэд гарган өгч болно.
- 10.2. Интернет суурилсан сүлжээгээр дамжуулсан (цахим хаяг, олон нийтийн цахим платформ) мэдээлэл нь аюулгүй байж чадахгүй бөгөөд дамжуулах явцад алдагдсан тохиолдолд үйлчилгээ үзүүлэгч хариуцлага хүлээхгүй.
- 10.3. Нууцлалын бодлого нь үйлчилгээний нөхцөлийн салшгүй хэсэг байна.

АРВАН НЭГ. Шимтгэл

- 11.1. Хэрэглэгч нь “Капекс Капитал” ХХК-аас баталсан Үйлчилгээний шимтгэлийн нөхцөлийн дагуу виртуал хөрөнгөн биржээс авч буй үйлчилгэтэй холбоотой шимтгэл хураамжийг төлөх бөгөөд Үйлчилгээний шимтгэлийн нөхцөлтэй бүрэн танилцаж зөвшөөрсөн болно. “Капекс Капитал” ХХК нь Үйлчилгээний шимтгэлийн нөхцөлд нэмэлт өөрчлөлт орсон тохиолдолд системд нийтлэх ба ийнхүү мэдээлэл нийтлэгдсэнээс хойш ажлын 1 өдрийн дараагаас эхлэн уг үйлчилгээний шимтгэлийн нөхцөл нь хүчин төгөлдөр мөрдөгдөнө.
- 11.2. Үйлчилгээний шимтгэлийн нөхцөлд заасны дагуу холбогдох шимтгэл, хураамжийг хэрэглэгчийн хэтэвчнээс ямар ч тохиолдолд суутган төлүүлэх эрхтэй байна.

- 11.3. Хэрэглэгчийн дижитал хөрөнгийн бирж дээр хийж буй арилжааны гүйлгээ тус бүрээс арилжааны шимтгэлийг Үйлчилгээний шимтгэлийн нөхцөлд заасан хувь хэмжээгээр төлөхийг зөвшөөрч байгаа болно.
- 11.4. ВХҮҮ-ийн үзүүлж буй зарим тусгай үйлчилгээтэй холбоотойгоор эсхүл системээр дамжуулан гуравдагч этгээдийн үзүүлж буй зарим үйлчилээний шимтгэлийг Мөнгөн хөрөнгөөр бус Виртуал хөрөнгөөр төлөхөөр тогтоосон байж болох ба энэ тохиолдолд Та тухайн үйлчилгээг авахдаа харгалзан Виртуал хөрөнгөөр үйлчилгээний шимтгэлийг төлнө. Виртуал хөрөнгийн шимтгэл нь Үйлчилгээний шимтгэлийн нөхцөлийн салшгүй хэсэгт тоочогдох бөгөөд Та уг шимтгэлийг төлөөгүй тохиолдолд Капекс Капитал ХХК болон үйлчилгээ үзүүлж буй гуравдагч этгээд Танд уг үйлчилгээг үзүүлэхээс татгалзах эрхтэй байна.
- 11.5. Та арилжааны үр дүнд бий болсон орлогоос үүдэлтэй Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу төлөх үүрэг хүлээх аливаа татвар хураамжийг хариуцан төлж барагдуулах үүрэгтэй болно. Бид таны төлөх татвар болон энд тусгагдсанаас бусад аливаа хураамжийг суутган авах үүрэг хүлээхгүй бөгөөд Таны татвар хураамж, төлөлттэй холбоотой аливаа үүргийг хариуцахгүй болно.

АРВАН ХОЁР. Санал хүсэлт

- 12.1. Хэрэглэгчид санал хүсэлт байгаа тохиолдолд info@capexcapital.mn цахим шуудангаар хандах боломжтой.